

“Материалимпэкс” хувьцаат компани

# ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН МАТЕРИАЛ

Улаанбаатар хот 2010 он

# МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 02 дугаар  
сарын 05 -ны өдөр.

Дугаар 04

Улаанбаатар хот.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын  
төлөвлөгөө, хугацаа тогтоох тухай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2010 оны 02 дугаар сарын 05-  
ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын зарыг 2010 оны 03 дугаар  
сарын 03-ны өдрийн сонинд нийтлүүлэн, хувь нийлүүлэгчдийн бүртгэх  
өдрийг 2010 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөр тасалбар болгон, 2010 оны  
04-р сарын 05-ны өдөр компани дээрээ зохион байгуулан явуулж хурлаар  
Компанийн 2009 оны ажлын болон санхүүгийн үйл ажиллагааны тайлан,  
2010 оны бизнес төлөвлөгөөг батлуулах тухай асуудлуудыг хэлэлцэхээр  
тогтоосугай.
2. Компанийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын бэлтгэл ажлыг ханган  
хурлыг удирдан зохион байгуулах комиссыг доорхи бүрэлдэхүүнтэйгээр  
томилон ажиллуулсугай.

Комиссын дарга: Б.Зориг /ТУЗ-ийн гишүүн, захирал/  
Гишүүд: Д.Оюун /ТУЗ-ийн гишүүн, хэлтсийн дарга/  
Д.Оюунчимэг /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/

3. “Компанийн тухай” хуулийн 68 дугаар зүйлийг үндэслэн 2009 оны хувь  
нийлүүлэгчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг доорхи  
бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга Г.Аюушмаа /ТУЗ-ийн гишүүн/  
Тооллогын комиссын гишүүд П.Сувд /ТУЗ-ийн гишүүн/  
Л.Нямдулам /ТУЗ-ийн гишүүн/

4. Компанийн тухай хуулийн заалтыг удирдлага болгон хувь нийлүүлэгчдийн  
хурлыг хуралдуулах тухай зар болон бэлтгэл ажлыг зохион байгуулалт  
сайтай явуулахын зэрэгцээ тооллогын комиссын ажлыг хууль зүйд  
нийцүүлэн зохих журмын дагуу явуулахыг дээрхи комиссын дарга нарт  
даалгасугай.



Д.ТУНГАЛАГ  
  
Б.ЗОРИГ

*Б. Чагаан*

Б.ЦЭРЭН

*Г.Дамбадорж*

*Л.Нямдулам*

*Б.Болортuya.*

*Д.Оюун*

*Г.Аюушмаа*

*П.Сувд*

# МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2010 оны 02 дугаар  
сарын 05-ны өдөр.

Дугаар 04.

Улаанбаатар хот.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн хурал 2010 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 14 цагаас Компанийн захирлын өрөөнд хуралдav. Хуралд: Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Тунгалаг, гишүүд Б.Зориг, Г.Дамбадорж, Б.Цэрэн, Г.Аюушмаа, Д.Оюун, Б.Болортuya, Л.Нямдуулам, П.Сувд нар оролцов.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Тунгалаг нээж, хэлэлцэх асуудлыг танилцуулахад, гишүүд хэлэлцэх асуудлуудыг 100%-ийн саналтайгаар батлав. Үүнд:

Компанийн захирал Б. Зориг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нийт ажилчин албан хаагчдын тайлангийн хурлыг 2010 оны 02 дугаар сарын 06-ны өдөр улмаар хувь нийлүүлэгчдийн хурлыг 04-дүгээр сарын 05-ны өдөр хуралдуулах саналаа танилцууллаа. Хуралд оролцогч төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд хувь нийлүүлэгчдийн хурал хуралдах өдөр, хурал зохион байгуулах комисс, хурлын тооллогын комисс түүнд оролцож байгаа бүрэлдэхүүнийг батлаж тогтоол гаргахыг зөвшөөрөв.

Шийдвэр:

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд дээрхи асуудлын талаар ярилцаж 2010 оны 04 дүгээр сарын 05-ны ханш нээж байгаа билэгт сайн өдөр хувь нийлүүлэгчдийн хурал хуралдуулах, хуралтай холбогдох комиссуудыг сонгох шийдвэрийг гаргаж, тогтоолыг батлав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

ТУЗ-ИЙН ДАРГА

Д.ТУНГАЛАГ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН Н/Б ДАРГА

Д.ОЮУНЧИМЭГ

МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ  
НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ИРЦИЙН МЭДЭЭЛЭЛ.

2010 оны 04- р сарын 05.

15.00 цаг.


Материалимпэкс хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын ирцийг танилцуулья.

Хувь нийлүүлэгчдийн хуралд ирвэл зохих 1 368 206 /нэг сая гурван зуун жаран найман мянга хоёр зуун зургаа/ саналын эрхтэй хувь нийлүүлэгчдээс 1166951 /Нэг сая нэг зуун жаран зургаан мянга есөн зуун тавин нэг / саналын эрхтэй хувь нийлүүлэгчид хүрэлцэн ирсэн байна. Хурлын ирцын хувь 85,3% байгааг мэдээлж байна.

ТООЛЛОГЫН КОМИСС

КОМИССЫН ДАРГА

КОМИССЫН ГИШҮҮД



Г.АЮУШМАА

П.СУВД

Л.НЯМДУЛАМ

# МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛ ЯВАГДАХ ДАРААЛАЛ

2010 оны 04 дугаар  
сарын 05-ны өдөр.

Улаанбаатар хот.

- |   |   |
|---|---|
| 1. Хуралд оролцогсод болон хувьцаа<br>эзэмшигчдийн бүртгэл явуулах                              | Тоологын комисс<br>1. Г.Аюушмаа<br>2. П.Сувд<br>3. Л.НЯМДУЛАМ |
| 2. Ирцийн мэдээг хуралд оролцогсодод<br>танилцуулах   | Тооллогын комиссын дарга<br>Г.Аюушмаа                         |
| 3. Хурлыг нээж хэлэлцэх асуудал, хурлын<br>дэг, дотоод журмыг батлуулах                         | ТУЗ-ийн гишүүн, захирал<br>Б.ЗОРИГ                            |
| 4. Компанийн 2009 оны үйл ажиллагааны<br>болон санхүүгийн тайлан                                | Захирал<br>Б.Зориг  |
| 5. Компанийн 2010 оны бизнес төлөвлөгөө,<br>2009 оны ашиг хуваарилалтыг хэлэлцүүлж<br>батлуулах | Хэлтсийн дарга<br>Д.Оюун                                      |
| 6. Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон<br>асуулт хариулт, санал шүүмжлэл                    | ТУЗ-ийн дарга<br>Д.Тунгалаг                                   |
| 7. Тооллогын комисоос саналын хуудас<br>тарааж, тайлбар өгөх                                    | Тооллогын комисс  |
| 8. Саналын хуудсыг хураан авч хурал<br>түр завсарлах  | Комисс, хуралд оролцогсод                                     |
| 9. Хурлыг үргэлжлүүлэх тооллогын<br>комиссын тогтоол танилцуулах                                | Тооллогын комисс  |
| 10. Хувь нийлүүлэгчдийн хурлаас гарах<br>тогтоолуудыг танилцуулж батлуулах                      | ТУЗ-ийн дарга<br>Д.Тунгалаг                                   |
| 13. Хурлыг хааж үг хэлэх  | ТУЗ-ийн гишүүн, захирал<br>Б.Зориг                            |

## ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

КОМИССЫН ДАРГА

Б. 

Б.ЗОРИГ

Д.ОЮУН

Д.ОЮУНЧИМЭГ


# МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ, ДОТООД ЖУРАМ

2010 оны 04 дугаар  
сарын 05-ны өдөр.

Улаанбаатар хот.

1. Хуралд оролцогод болон хувьцаа  
эзэмшигчдийн бүртгэл явуулах  
Тооллогын комисс 30 минут.
2. Ирцийн мэдээг хуралд оролцогсдод  
танилцуулах  
Тооллогын комиссын дарга 5 минут.
2. Хурлыг нээж хэлэлцэх асуудал, хурлын  
дэг, дотоод журмыг батлуулах 5 минут.
3. Компанийн 2009 оны үйл ажиллагааны  
болон санхүүгийн тайлан 30 минут
4. Компанийн 2010 оны бизнес төлөвлөгөө, ашиг  
хуваарилалтыг хэлэлцүүлж батлуулах 10 минут.
5. Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон  
асуулт хариулт, санал шүүмжлэл Цаг тогтоохгүй
6. Тооллогын комисоос саналын хуудас  
тарааж, тайлбар өгч, хурааж авах 20 минут.
7. Саналын хуудсыг хураан авч хурал  
завсарлах, тооллогын комисс  
ажиллах 20 минут.
8. Хурлыг үргэлжлүүлэх тооллогын  
комиссын тогтоол танилцуулах 5 минут.
9. Хувь нийлүүлэгчдийн хурлаас гарах  
тогтоолуудыг танилцуулж батлуулах  
/ТҮЗ-ийн дарга/ 10 минут.
10. Хурлыг хааж үг хэлэх / хурлын дарга/ 5 минут.

Хурлыг 2 цаг дутам 15 минутын завсарлагатайгаар мөн өдөртөө багтаан явуулна.

## ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

КОМИССЫН ДАРГА

Б. ЗОРИГ

Д. ОЮУН

Д. ОЮУНЧИМЭГ

# МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2010 оны 04 дугаар  
сарын 05-ны өдөр.

Дугаар 01

Улаанбаатар хот.

Компанийн 2009 оны үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагааны тайлан, компанийн 2010 оны бизнес төлөвлөгөө батлах талаар бичгээр санал хураахад нийт 1166951 саналын эрхтэй хувьцааны 7 ширхэг хуудас тоолсон дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тооллогын комиссоос саналын хайрцагийг нээж шалгахад 7 хуудас гарсныг хүчинтэйд тооцсугай.
2. Хүчинтэйд тооцогдсон саналын хуудсаар дүгнэхэд хэлэлцүүлж байгаа асуудлыг доорхи хувиар зөвшөөрснийг тогтоосугай. Үүнд:
  1. Компанийн 2009 оны үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагааны тайланг 100 хувь зөвшөөрсөн.
  2. Компанийн 2010 оны бизнес төлөвлөгөө, ашиг хуваарилалтыг 100 хувь зөвшөөрсөн.

## ТООЛЛОГЫН КОМИСС

КОМИССЫН ДАРГА

КОМИССЫН ГИШҮҮД



Г.АЮУШМАА

П.СУВД

Л.НЯМДУЛАМ

# МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 04 дугаар  
сарын 05-ны өдөр.

Дугаар 01

Улаанбаатар хот.

Тайлан, төлөвлөгөө  
батлах тухай.

Хувь нийлүүлэгчдийн хурлын тооллогын комиссын 2010 оны 04 дүгээр  
сарын 05-ны өдрийн 1-р тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2009 оны үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагааны тайлан мэдээллүүдийг баталсугай.
2. Компанийн 2010 оны бизнес төлөвлөгөө, 2009 оны ашиг хуваарилалтыг баталсугай.
3. Тайлант оны үйл ажиллагааны ололтоо бататган хувь нийлүүлэгчдээс гаргасан санал шүүмжлэл санаачлагыг үйл ажиллагаандaa тусган зорилгоо биелүүлэхэд тодорхой бодлого чиглэл боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл, удирдлагад үүрэг болгосугай.



Д.ТУНГАЛАГ  
Б.ЗОРИГ  
Б.ЦЭРЭН  
Г.ДАМБАДОРЖ  
Л.НЯМДУЛАМ  
Б.БОЛОРТУЯА.  
Д.ОЮУН  
Г.АЮУШМАА  
П.СУВД

# **МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2010 оны 04 дугаар  
сарын 05-ны өдөр.

Дугаар 01.

Улаанбаатар хот.

“Материалимпэкс” ХК-ний хувьцаа эзэмшигч бүх гишүүдийн хурал 2010 оны 4-р сарын 05-ны өдрийн 15.00 цагт компанийн хурлын байранд боллоо.

Хуралд 1 368 206 саналын эрхтэй хувь нийлүүлэгчдээс 1166951 саналын эрхтэй хувьцаа эзэмшигч ирсэнээр хурлын ирц 85,3 хувь байгаа тул хурлыг эхлэхээр боллоо.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Тунгалаг захирал Зоригийг хурлын даргаар томилж, хурал удирдуулах үүрэг өгөв. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, хурлын дарга Б.Зориг хурлын дотоод журам дэгийг танилцуулан гишүүдээр хэлэлцүүлэн батлуулж хуралд хэлэлцэх асуудлыг нэг бүрчлэн танилцууллаа. Компанийн 2009 оны үйл ажиллагааны болон санхүүгийн хяналтын тайланг бүх гишүүдэд урьд нь тарааж танилцуулсан тул үг хэлж санал шүүмжлэл гаргах боллоо.

**Д.Тунгалаг:** Манай компани Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвтэй жил бүр гэрээ байгуулж ажиллан, хувь нийлүүлэгчдийн судалгаа, түүний тархалтын мэдээг гаргуулан авч танилцаж ирсэн. Одоогийн байдлаар 1824 хувьцаа эзэмшигчидтэй, эдгээрээс хувьцааны оролцоогоор 85,3% нь хуралд оролцож байна.

Бид 2009 онд компанийн дотоод хяналтыг сайжруулж, ажлын уялдаагаа сайруулж ирснээр алдлагдлаас гарч, ашигтай ажиллаж чадсан. Цаашид удирдах зөвлөл дээрээ ажлаа төлөвлөн тохирсон зүйлийг төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулж байх хэрэгтэй.

Ажиллагсдын нийгмийн асуудалд байнга санаа тавьж, тэднийг байгууллагаа гэсэн өөриймсөг сэтгэлтэй болгох, товчоор хэлэхэд компанийнхаа төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэдэг зарчим баримталж ажиллах хэрэгтэй.

**Г.Аюушмаа:** Хурлын материалтай танилцаж байхад үйл ажиллагааны хүрээ багассан ч үр ашиг нь дээшилсэн үзүүлэлт харагдаж байна. 1998 оноос хойш компани ашигтай ажиллаж байгаагүй. Гэхдээ энэ хугацаанд маш олон ажлын байрыг нэмэгдүүлж, үйлдвэрлэл үйлчилгээний шинэ төрлийг ажилд оруулж, ашиглалтанд авч байсан боловч нэг нь ч үр дүнгээ тууштай өгөөгүй гэж хэлж болно.

Компани олон жил алдагдалтай ажилласан гол шалтгаан нь хувьчлалын өмнөх үед тодорхой бүлэг төрийн өмчөөр тоглож дэндүү их өрөнд унагасан / оруулсан/ явдал байлаа. Хувьчлахын өмнө үе/1999 оноос өмнө/-д ажиллаж байсан хүмүүс компанийг хэрхэн унагаж өр төлбөртэй болсоныг мэдэх хүн байгаа. Энэ нь 13 жил компани алдагдалтай ажиллах шалтгаан болсон. Харин хувьчилж авсан хүмүүс их тэвчээр гаргаж, зөв менежмент

явуулсаны үр дүнд их өрийн 50 гаруй хувийг дарж балансаар ашигтай гарсан харагдаж байна.

Гэхдээ хувьчлалын материалд суугдсан их өрийн үлдэгдэл байгаа гэдгийг санаж явах учиртай. 2009 он хямралын жил байсан болохоор хүн бүр зардлаа хэмнэх, хямгадах бодлого барьж ажилласан. Үүний дотроос хамгийн их бараа оруулж ирсэн хүн бол Б.Зориг байх. Хэрэв тээвэр зуучлал ингэж сайн ажиллавал компанийн ашиг орлого улам нэмэгдэж, бидний хүсэж мөрөөдөөд байгаа цалин ахих учиртай.

Д.Оюун: 2009 онд балансийн үзүүлэлтээр ашигтай ажилласан боловч энэ ашиг нь 2008 онд алдагдал нь шингээд 2009 онд үлдэх ашиг нь орж байгаа шүү. Тиймээс компани 2009 онд 141,9 сая төгрөгийн ашигтай ажиллаа.

Олон жил алдагдалтай ажиллаж, гааль, төмөр зам, мэргэжлийн хяналтын газраас агуулахын өнгө үзэмж, ахуй байдлыг сайжруулах талаар олон удаа сануулга авч байсныг би сайн мэдэх учраас эхний ээлжинд агуулахаа шинэчлэх, орлогоо нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрлэлийг өргөтгөхөд хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй гэж бодож байна.

Ийм учраас ашиг хувиарилалтанд доорхи санал өгч байна. 42 595 950 төгрөгийг Хувьцаа эзэмшигчдийн ноогдол ашигт тарааж үлдэх 99 390 546 төгрөгийг хөнгөн блокны үйлдвэр, 3,4,5-р агуулахын шинэчлэлд хөрөнгө оруулалт хийхэд зарцуулах саналтай байна.

Хэлтэс нэгжийн дарга, удирдах ажилтан, менежерүүдийн өгсөн саналыг үндэслэн 2010 оны төлөвлөгөөг боловсруулаад хоёрдугаар сарын 05-ны өдрийн удирдлагын зөвлөлийн гишүүд болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэж, одоо нийт хувьцаа эзэмшигчид та бүхэнд танилцуулж байна.

Энэхүү 2010 оны төлөвлөгөө болон хурлын материалыг урьдчилан тарааж холбогдох хүмүүсээс санал авч, тэдний саналыг төлөвлөгөөнд тусган 122,2 сая төгрөгийн ашигтай ажиллах тооцоо гарч байна. Тус компани 2010 оноос өөрийн үйл ажиллагаагаараа бодит ашигтай ажиллах бүрэн боломжтой гэж үзэж байна.

Д.Оюунчимэг: Тайллангаас харахад сүүлийн 11 жилд алдагдалтай ажиллаж байгаад энэ 2009 онд 141,9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан сайхан амжилт гаргалаа. Санхүү тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий ня-бо Д.Оюуны тавьж байгаа саналыг хувьцаа эзэмшигчийн хувьд дэмжиж байна. Мөн 2010 оны төлөвлөгөөтэй урд нь төлөөлөн удирдах зөвлөлийн хурал дээр танилцаж байсан.

Төлөвлөгөө нормоо амжилттай биелүүлэхийн тулд гадаад дотоод худалдааг төрөл бүрээр өргөтгөхийн дээр орлого олох ямар суваг байна түүнийг соргогоор хүлээн авч хөгжүүлэх, холбогдох мэргэжлийн ажилтан нар мэдлэг боловсролоо дээшлүүлж, санаачлагатай ажиллан, дадлага туршлагатай хүмүүсээс сурч мэдэж харилцан бие биендээ туслаж ажиллаваас бидэнд зорилгодоо хүрэх бүрэн боломж байгаа гэж үзэж байна.

Д.Тунгалаг: Эхний ээлжинд компанийн агуулах, тоног төхөөрөмж, техникийг шинэчилж, фонд өгөмжийг дээшлүүлэх, нийгмийн хариуцлагыг

сайжруулах, өөрийн ажилчдын амьдрал ахуйг өөд татахад чиглэх ёстой. Хөнгөн блок, дээврийн төмрийн үйлдвэр барьж ашиглалтанд оруулахад 62,5 сая төгрөг, агуулахын суурин шинэчлэл, бусад барилга засварын ажилд 36,9 сая төгрөг бүгд 99,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй.

Ня-бо Д.Оюуны тавьж байгаа саналыг хянаж үзээд, ноогдол ашигт 42,5 сая төгрөг шилжүүлэхийг дэмжиж байна. Энэ нь нэгж хувьцаанд 31,13 төгрөг тараах юмаа. Томоохон хувьцаа эзэмшигчдийн ноогдол ашгийг өөрийн компаниар олгох нь зүйтэй байх, бусдыг гэрээ хийн мэргэжлийн байгууллагаар тараалгая гэж бодож байна.

**Г.Аюушмаа:** Компанийг цаашид улам ашигтай ажиллуулахад тээвэр зуучлалын чингэлэгийн тоог нэмэгдүүлэх, зардал багатай агуулахын аж ахуйгаа дэмжих хэрэгтэй байна. Нэгэнт ашигтай ажиллаж эхэлсэн тохиолдолд ноогдол ашиг хуваарилах, хөрөнгийн биржид төлөх татвар төлбөрийн хэмжээ нэмэгдэх болно. Энэ бүгдийг тооцож гаргах нь зардал хянах ашиг зөв хуваарилахад нөлөөтэй. Манай компанийн гишүүдийн сонирхож байгаа зүйл нь ашиг хуваарилахыг харж байгаа.

Д.Оюуны хэлж байгаагаар нэг ширхэг хувьцаанд 31.13 төгрөг олгогдож болохоор юм байна. Үүнийгээ гишүүдийн хурлын шийдвэрээрээ хөрөнгийн биржээр дамжуулан хувьцаа эзэмшигчдээ олгох саналтай байна. Бид цаашдаа үйлчлүүлэгчдийг дээдлэн хүндэлж, угтаж үйлчлэн, хүнээ гэсэн чин сэтгэлтэй, ирээдүйгээ харсан ухаалаг бодлоготой ажиллах хэрэгтэй.

**Б.Зориг:** Бид 1999 оноос тэр их өрийг төлж багасгахад маш их цаг хугацаа, хөрөнгө зарлаа. Цаашид бид мөнгө санхүүгийн бодлогыг улам нягт байлгаж, зээлийн болон худалдааны үйл ажиллагаагаа зах зээлтэйгээ сайн уялдаатай явуулах шаардлага байна. 2009 оныг санхүүгийн ахицтай жил болсон гэж үзэж байна.

Би одоо тээвэр зуучлалын үйл ажиллагааг яаж өргөжүүлэх вэ гэдэгт их анхаарах хэрэгтэй. Өргөжүүлэх гэдгийг чингэлэгийн хүлээн авах тоог нэмэгдүүлэхээс гадна усан болон агаарын тээвэр, авто тээвэр өөр бусад үйлчилгээний төрлүүдэд үйлчилгээ нэмэгдүүлэх чиглэлээр ажиллахыг хүсэж байна.

Одоо бид хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг тууштай хамгаалж тэдний хувьцааны үнэ цэнийг мэдүүлж, хувьцаа эзэмшигч нартай ойр дотно ажиллах шаардлагатай. Манай хувьцаа эзэмшигч нар манайхаар үйлчлүүлж байвал өөрөө өөртөө хөрөнгө оруулалт хийж ашиг орлогоо нэмэгдүүлж байгааг санхүү хяналтын болон тээвэр зуучлалын нөхөд сайн ойлгуулах хэрэгтэй.

**Д.Оюунчимэг:** 2010 оны төлөвлөгөөнд: Нийт 7420,1 сая төгрөгийн орлого олж, 122,2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар, нэг хүний нэг сарын хөдөлмөрийн бүтээмжийг 11,2 сая төгрөг, дундаж цалинг 300 гаруй мянган төгрөгт хүргэж, жилийн цалингийн санг 200 гаруй сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Хөдөлмөрийн бүтээмж дундаж цалингийн зохист харьцаа алдагдаагүй харагдаж байна.

Манай компани чинь нэр хүндтэй, том компани учраас компанийг хамгийн үнэт капитал болох чадвартай мэргэшсэн боловсон хүчнээр бэхжүүлэн, ажиллагсадынхаа амьдралын баталгааг хангахуйц цалин олгож чадахгүй ч гэсэн нийгмийн асуудалд анхаар ч ажиллах хэрэгтэй, болж өгвөл цөөн чадвартай хүнтэйгээр ажиллаж цалинг нь оруулсан орлого, юу хийж бүтээсэнтэй нь холбож хийснээр цалинжуулах системд шилжих нь зүйтэй.

Цаашид ажиллагсдын ажлын нягтралыг сайжруулах, үргүй зардлыг багасгах, барааны эргэцийг түргэтгэх, гадаадын түншүүдийг нэмэгдүүлэх, банкны зээлийг багасган санхүүгийн чадвараа сайжруулах шаардлагатай.

Ингээд компанийн 2009 оны тайлан болон, 2010 оны бизнес төлөвлөгөө, ашиг хуваарилалт, санхүүгийн хянан шалгагчийн тайланг батлах саналтай байна.

Б.Зориг: Ашиг хуваарилах болсон нөхцөлд хувьцаа хөрөнгө оруулалт, хөрөнгийн эзэн гэсэн ойлголт улам нэмэгдэх болно. Үүнээс үүдэж манай хувьцааны ханш өсөх нөхцөл бий болно. Хөрөнгөөр баталгаажсан хувьцааг улам үр ашигтай байлгахад бид анхаарч ажиллах ёстой. Санхүүгийн хэлтсийн дарга Д.Оюуны саналыг дэмжиж, төлөөлөн удирдах зөвлөлийн даргын саналтай нэг байна. Цаашид хувьцаа ээмшигчдийн санал, шүүмжлэлийн мөрөөр тодорхой арга хэмжээ авч ажиллана.

Өөр үг хэлэх хүн байгаа эсэхийг хурал удирдагч хуралд оролцогчдоос санал асуухад өөр саналтай хүн гарсангүй.

Санал авах хуудсанд компанийн 2009 оны үйл ажиллагааны болон санхүүгийн хянан шалгагчийн тайлан, 2010 оны бизнес төлөвлөгөө батлахад хуралд оролцогчдын 100 хувийн саналаар 2009 оны компанийн тайлан, 2010 оны бизнес төлөвлөгөөг баталлаа. Хурал түр завсарлав.

хурлын ажиллагаа 17.30 цагт дуусав.

Хурлын тэмдэглэлтэй танилцаж  
зөвшөөрсөн: ТУЗийн дарга

Д.Тунгалаг

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:  
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Д.Оюунчимэг

МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИАС  
2009 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН  
АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2010 оны 01 дүгээр  
30-ны өдөр

Улаанбаатар  
хот

Тайлант онд тус компани харилцагч байгууллага, хувь хүмүүст үйлчлэх үйлчилгээг хөнгөн шуурхай соёлч боловсон явуулах, ажилчдын нийгмийн хамгаалал, сахилга дэг журам харицлагыг дээшлүүлэх, өртөг зардлыг хямдруулах, зээл, зээлийн хүүг төлж барагдуулах чиглэл барьж доорхи ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн хурлыг зохих бэлтгэлийг хангасны үндсэн дээр хуулийн хугацаанд нь болон шаардлагатай үеүдэд нь хийж байсанаас гадна компанийн өмнө тавигдаж байгаа цаг үеийн асуудлуудыг удирдлагын хүрээнд хэлэлцэж ирсэн бөгөөд гарсан шийдвэрийг хамт олонд мэдээлэх ажлыг хурал цуглаанаар болон баримт бичгээр танилцуулах журмаар гүйцэтгэж ирсэн

Тайланд онд ажиллагсдын шилжилт хөдөлгөөн болон бусад шаардлагатай асуудлуудын талаар 40 тушаал гарсны 20 гаруй хувь нь хүмүүсийн шилжилт хөдөлгөөнтөй, 70 гаруй хувь нь удирдамжийн шинж чанартай тушаал гарсан нь өнгөрсөн онтой харьцуулбал шилжилт хөдөлгөөнтөй холбоотой тушаалын тоо буурч удирдамжийн чанартай тушаал нэмэгдсэн байна

2009 оны 2 дугаар сард компанийн бүтэцэд өөрчлөлт оруулсан. 3 хүн шинээр ажилд орж, 3 хүн дотроо шилжилт хийж, 4 хүн хувийн хүсэлтээр, 2 хүн архи согтууруулах ундаа хэрэглэсэнээс, 3 хүн ажлын хариуцлагаар, 8 хүн орон тооны цомхогтогоор чөлөөлгдсөн байна. Шинээр ажилд орсон хүмүүсийн хувийн хэрэг шинээр бүрдүүлэх, хөдөлмөрийн гэрээ байгуулах ажлыг хийлээ.

Гэвч зарим хүмүүсийн хувьд ажилд хариуцлагаагүй, санаачилгагүй, хандах, ажлын байр талбайд архи согтууруулах ундаа хэрэглэх, энэ талаар бусдыг уруу татах, анхаарал, сонор сээрэмж муугаас бараа материал алдаж үрэгдүүлэх явдал байсаар байгаад дүгнэлт хийж хүн бүр байгууллагаа, хамт олноо гэсэн эрмэлзлэлээр ажиллахыг анхааруулж байна. Компанийн удирдлагуудаас амьдрал ахуйд нь гачигдал хүндрэл тохиолдсон ажилтнууд, өндөр настнуудад зохих тэтгэмж тусламж үзүүлэх талаар өөрийн мөрдөж байгаа журамдаа тулгуурлан зохих хэмжээгээр анхаарч ирсэн бөгөөд тухайлбал 6 хүнд 340000 төгрөгийн буцалтгүй тэтгэмж тусламж 4 хүнд 450 гаруй хоногийн чөлөө олгожээ. Чөлөө олгож байсан хугацаа харьцангуй өндөр байгаа нь хүүхэд асрах чөлөө авалттай холбоотой байлаа.

Ажиллагсдыг эмнэлгийн үзлэгт хамруулсанаар хүмүүс өөрийн эрүүл мэндээ анхаарах дараагын эмчилгээний суурийг тавьж өгсөн сайн зүйл болсон гэж үзэж байна. Бүх хүмүүсийг албны шугамаар өөр хоорондоо үнэгүйгээр ярих гар утастай болгосон нь холбооны зардал хэмнэсэн ажлын бүтээмж дээшилхэд нөлөөлсөн арга хэмжээ боллоо. Мөн ажлын үр дүнгээр шагнаж урамшуулах, зэмлэл щийтгэл ноогдуулах зарчмаар ажиллаж ирсэн бөгөөд хариуцлага, сахилаа алдсан. 8 хүнд

захиргааны шийтгэл ноогдуулж. б. хүнд 300000 төгрөгийн шагнал олголоо. Тайлант онд тус компани ажиллагсад, өндөр настнууд болон бусад иргэдээс 8 өргөдөл хүлээн авч хуулийн хугацаанд зохих шийдвэрүүдийг гарган эздэд нь мэдэгдэж ирсэн. Компани өөрийн үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбогдуулан гадагш 190 албан буучиг факс илгээж, дотоод гадаадын байгууллагуудаас албан бичиг 46-ыг хүлээн авч хариуг нь өгч ажилласан байна. Мөн онд урьд гарсан эрхийн актын шинж чанартай баримт бичгүүдэд шүүлт хийж шаардлагагүйг хүчингүй болгох, зарим баримт бичгийг цаг үеийн байдалтайгаа уялдуулан өөрчлөх ажлуудыг хийж гүйцэтгэсэн юм

Тайлангийн хугацаанд компанийн удирдлага, санхүү эдийн засгийн үйл ажиллагааг эрхлэн явуулж байгаа хүмүүсийн үйл ажиллагааны үрээр хөрөнгө мөнгөний төвлөрүүлэлт, зээл, өглөг, зээлийн хүүний өр зэргийг барагдуулах талаар багагүй ахиц амжилт гаргасан гэж үзэж байна. Мөн онд агуулах талбайн ашиглалтыг сайжруулах гэрээ түрээсээс орох орлогыг нэмэгдүүлэхэд анхаарч ирсэн бөгөөд 30 гаруй байгууллагатай түрээсийн гэрээ байгуулан ажмлаж конторын өрөө тасалгааны түрээсээс. 48510,, мянган, агуулахаас. 123864,5. мянган, телефоноос 1463,3. мянган, цахилгаан дамжин хэрэглэлтээс 10246,9 мянган, зам, талбай гаалийн баталгаат агуулахын ашиглалтаас 136916 .мянган, дотоод үйлчилгээнээс 14572,2 мянган, талбайн үйлчилгээнээс 198553,8 мянган борлуулалтын орлого-Хүнс 5966622. мянган, Борлуулалтын орлого-Сантехник 189,1 мянган, Борлуулалтын орлого-Цемент 67005 мянган, чингэлэг тээвэрлэлтээс 672286,5 .мянган төгрөг буюу нийт 7285793 мянган. төгрөгийн орлого орсон байна.

Ингэсэнээр 2009 онд нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татвар бусад төрлийн татвар хураамж цаг хугацаандаа бүрэн төлөгдсөн байна. Мөн газрын төлбөрт 75293,5 мянга, нэмүү өртгийн албан татварт.....мянган төгрөг төлсөн байгаа. Агуулах байрны засварт. 25804,8 мянган төгрөг, суурин краны засварт 7457,9 мянган төгрөг, ажиллагсдын цалинд 138662,1 мянган төгрөг, холбоонд 9306,8 мянган төгрөг, цахилгаанд 24050,5 мянган төгрөг, дулаанд 13684,4 мянган төгрөг, бинзен шатах тослох материал. 10688,8 мянган төгрөг, бичиг хэрэгсэл албан томилтод 9509,2 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Компани 2009 онд сар улиралын тайлан балансыг графикт хугацаанд гаргаж Далай ван аудитын байгууллагаар баталгаажуулан татвар санхүүгийн байгууллагуудад тушааж ирсэн байна. Гаалийн 5 мэдүүлэгч үндсэн ба нэмэлт, хавсралт 9868 мэдүүлэгийн бүрдүүлэлт хийж 39770505 төгрөгийн орлого оруулсан байна. Мөн нэмүү өртгийн албан татварын тайлан, хүн амын орлогын тайлан, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангуудыг гаргаж холбогдох газруудтай тооцоо хийж ирлээ. Тус компани оны эцсийн байдлаар 4427834 мянган төгрөгийн эргэлтийн, 1466772 төгрөгийн эргэлтийн бус, 1939845 мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөр, 1943824 мянган төгрөгийн урт хугацаат өр төлбөр байгаа бөгөөд компанийн жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 7284714. мянган төгрөгийн орлого олж, нийт зардалд 7091070. мянган төгрөг зарцуулж 193644. мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Компани тайлант онд өөрийн контор ажилчдын байр, дулаан, уур, ус, цахилгаан, машин тоног төхөөрөмжийн хангалт бэлэн байдалд өөрийн ажил, анхаарлыг

төвлөрүүлэн ажиллаа. Халаалтын шугам хоолойнууд удаан жилийн ашиглалтын улмаас муудсан түүнчлэн хаг тундас үүссэнээс халаалт муу болсонтой холбогдуулан хэсэгчлэн засвар үйлчилгээг хийх дулаан хангалтын өрөнхий шугаманд хаалтууд солих, шинээр тавих /4ш/ зэрэг ажлуудыг өөрийн сантехникч, гагнуурч нарын хүчээр хийснээр халаалт үндсэндээ хэвийн явагдаж байна. Мөн конторын нэг, хоёрдугаар давхарын ариун цэврийн өрөөний суултуур, угаагуур, хөтөвч зэрэг тоноғлол холболтонд гэмтэл гарсан тухай бүрт нь засвар үйлчилгээ хийж ирсэн.

Дулаан, цэвэр усны зардалыг хэмнэх шаардлагын үүднээс бүх тоолууруудыг баталгаажуулалтанд хамруулж, цахилгаан, дулаан дамжуулан хэрэглэгч нарийн шугамд хяналт тооцоолот хийсны үр дүнд 2008 онтой харьцуулахад зардал тодорхой хэмжээгээр буурсан дүн гарч байна. Компаний хэмжээнд хэрэглэж байгаа цахилгаан эрчим хүчний хэрэглээнд байнга хяналт тавьж байх, зардлыг хэмнэж ажиллахын тулд гадны хэрэглэгчтэй хийх гэрээ, тооцоог тодорхой болгож, шугамын алдагдлыг багасгах, найдвартай ажиллагааг хангах чиглэлийн ажлуудыг хийж ирлээ.

Цаашдаа цахилгааны шугам, мантаж, холболтуудад үзлэг хийж засварлах шаардлага байгаа. Мөн тээвэр зуучлалын үйл ажиллагаа буюу гаалийн хяналтын бүс түүний дотор өндөр даацын гурван краны бэлэн байдал хамгаас чухал байгааг хүн бүр мэдэж байгаа. Иймд энэ крануудыг хэвийн ажиллагаатай байлгах талаар багагүй анхаарч байна. Кранд шаардлагатай сэлбэг материалыг зах зээлийн үнээс хямдаар олж нийлүүлэх, хуучин сэлбэг материалаар сольж авах, орлуулж хийх олон арга хэрэглэж зардал хэмнэх бүх бололцоог ашиглаж ирсэн.

Өөрийн хүмүүсийн хүчээр шаардлагатай тосолгоо, үйлчилгээ хийж явах ангийн редукторын араа сольж, тодорхой хугацаанд задаргаа, тохируулга хийж байсан бөгөөд гол солих, цахилгаан хангамжийн сүлжээнд хэсэгчилсэн засвар хийх, тэжээлийн кабелийг муфтилэх, трос шинэчлэн солих ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Гаалийн хяналтын бүсэд ажлын байр конторын болон хувцас солих вагончиг хоёрыг байрлуулж тохижуулан ажилд оруулсны гадна төмөр замын гаралнуудыг тэмдэгжүүлэх ажлыг хийж мөн тросыг өөрийн дотоод нөөц бололцоондоо тулгуурлан сүлжсэнээр 400 мянган төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

Тайлант онд кранд иж бүрэн магадалгаа мэрэгжлийн байгууллагаар хийлгэж, оосорлогч дохиочны курс хичээллүүлэн ажилчдыг мэргэжлийн үнэмлэхтэй болгосон. Авто машин, хөдлөх бүрэлдэхүүнийг улсын үзлэгт оруулж, сэлбэх зүйлийн жагсаалт гарган зардлын тооцоолол хийж удирдлагад танилцуулан уг ажлыг ээлж дараалалтай хийж, гаалийн баталгаат агуулахын дээвэрийн засвар ил задгай төмөрийг агуулахад оруулах ажлуудыг хийлгээ

Тээвэр зуучлалын алба 2009 онд гадаадын харилцагч агентлагуудын найдвартай хамтын ажиллагаа, хямд үнэнд онцгой анхаарч гадаадын 20 гаруй агентлагтай хамтран ажиллаж ирсэн. Үйл ажиллагаа сайжируулахын тулд талбайн гэрэлтүүлэгийг сайжируулах, талбайд мөрдөх журмыг шинчлэх, хаяг адерсыга тодотгох, төмөр замын арчилгаа, цэвэрлэгээг тогтмолжуулах, талбайн ажилчдыг хувцсаар хангах зэрэг арга хэмжээнүүдийг авсан болно. Тайлант онд тус компани Солонгос, Япон, БНХАУ, Сингапур, Хонг-конг, Бразил, Франц, Малайз, Турк зэрэг

орнуудаас 386 чингэлэг хүлээн авсан нь өнгөрсөн оноос 3 дахин буурсан бөгөөд ирсэн барааны ихэнх нь машин, хүнсний бараа байлаа. 2009 онд экспортын үйл ажиллагаагаар 66 чингэлэг 2140 вагон барааг гаргасан бөгөөд гаргасан барааны ихэнх нь бэлэн хувцас, мал хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн байлаа.

Үүнээс гадна Алейск, Мона-алтай, Өөг, Арвин үндэс Сетимпэкс зэрэг 30 гаруй компани хүмүүсийн 2342 вагон барааг тээвэрлэн, зохиц баримтуудыг нь бүрдүүлэн эзэд нь олгох ажлыг зохион байгуулсан бөгөөд энэ чиглэлийн тээвэрлэлт өнгөрсөн оноос 27 хувиар буурсан байна.

Тээвэр зуучлалын ажлыг хөдөлмөрчид, хамтран ажиллагч байгуулага хувь хүмүүст чирэгдэлгүй хөнгөн шуурхай байдлаар явуулахыг өөрийн эрхэм зорилт болгон дэлхийн зах зээлд хүртэл сайжируулах шаардлага байна. Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад тулгууралсан олон нэр төрлийн бүтээгдэхүүн импортлон, үйлчилгээний оновчтой менежмент хэрэшжүүлж, тогтвортой үйл ажиллагаа явуулсны үр дүнд 2009 оны Импортын онцлох "Энтрепренёр"-оор шалгаран "Хүрэл Меркури", Хүндэт өргөмжлөлөөр шагнагдсан. Энэ нь хамт олон та бүхний хөдөлмөрийг үнэлсэн үнэлгээ юм.

Гэвч дадлага туршилагатай ажилтан цөөн, зах зээлийн нөхцөлд түншээ зөв сонгож чадахгүй байгаас болж гадны зуучлагч байгууллагын хяналтанд орж ачаа саатах, хугацаа алдаж болзошгүй байгааг анхаарч ажиллах шаардлагатай байна. Мөн тээвэр зуучлалын ажлын дотоод зохион байгуулалтыг сайжируулах шаардлага байгаа гэж үзэж байна. Зах зээлийн өнөө үед байгууллагын ажил үйлчилгээний талаар сурталчлагaa сайн явуулах нь үйл ажиллагааг идэвхижүүлэх нэгэн хөшүүрэг байх ёстой юм. Гэвч өнгөрсөн онд үндсэндээ сурталчилгааны ажил хийгдсэнгүй.

Компани ажиллагсдын өдөр дутмын үйл ажиллагаандaa хэрэглэгдэх хангамжийн материал, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувцас, цэвэрлэгээ ариутгалын бодис, машин техникийн сэлбэг, цахилгаан дулааны шугам сүлжээтэй холбогдсон сэлбэг материал зэргийг олж бэлтгэх түүнийг тавьж олгох зэрэг арга хэмжээнүүдийг авч ирлээ. Компаниас байгууллага орчноо цэвэр үзэмжтэй байлгах зорилгоор нийтийг хамарсан цэвэрлэгээ болон хэсэгчилсэн цэвэрлэгээг З удаа хийж ирлээ. Цаашид шарилж өндөр ургахаас өмнө түүх, устгах, мод зүлэг тарих ажлыг хийх шаардлагатай гэж үзэж байна.

Материалимпэкс констракшин охин компани тайлант онд үйл ажиллагаа бараг явуулаагүй бөгөөд жилийн эцсийн балансын дунгээр алдагдалтай ажилсан байна. Монгол импери турс охин компани 2009 онд үйл ажиллагаа явуулаагүй байна.

Цаашид хөрөнгө санхүүгийн хувьд тогтвортой байдал бий болгож, үйл ажиллагаагаа идэвхжүүлэн ашигтай ажиллуулах

Хүн бүр ажилдаа эзний ёсоор хандаж, сахилга хариуцлагаа өндөржүүлэн, зардал хэмнэх, үр ашиг олох санал санаачилгуудыг гарган үйл ажиллагаандaa хэрэгжүүлэх

Тээвэр зуучлалын ажлын дотоод зохион байгуулалт үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх

Баирлын ажлын фронт олж ажилтай байх бүх боломжит арга хэмжээг авах

Ажиллагсдын нийгмийн асуудалд онцгой анхаарч, тэдний дунд зохиох урлаг

спортын арга хэмжээг нэмэгдүүлж хөдөлмөрийн идэвхийг өрнүүлж ажиллах

Ажиллагсдын хөдөлмөрийн үнэлгээг улам сайжируулж, зэмлэл шийтгэл, урамшил шагналыг зөв хослуулж ажиллах.

Хувь нийлүүлэгчдийн 2010 оны 04-р сарын 05-ны өдрийн хурлаар батлав.

**МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2009 ОНЫ  
ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ  
2010 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ**

/мянган төгрөгөөр/

ДД	Үзүүлэлтүүд	2008 оны гүйцэтгэл	2009 оны		2010 оны төлөвлөгөө	
			төлөвлөгөө	Гүйцэтгэл тайлангаар	Санал	баталсан
1	Барилгын барааны борлуулалт	397099.6	500000.0	69262.7	500000.0	500000.0
2	Хүнсний барааны борлуулалт	4562727.7	3000000.0	5966622.0	5000000.0	5000000.0
3	Нийт бараа борлуулалт	4959827.3	3500000.0	6035884.7	5500000.0	5500000.0
4	Бараа борлуулалтаас олох орлого		50000.0			
5	Түрээсийн орлого	135872.2	150000.0	172375.2	204138.5	204138.5
6	Экспорт-импорт контейнерын орл/	1686767.7	800000.0	672986.6	1095000.0	1095000.0
7	Дотоод үйлчилгээний орлого	42067.8	20000.0	14572.2	15000.0	15000.0
8	Гаалийн баталгаат агуулахын орлого	7149.9	8000.0			
9	Дамжин өнгөрөх түрээсийн орлого			12729.1	11000.0	11000.0
10	Гаалийн орлого /мэдүүлгийн/	54061.1	30000.0	39770.5	30000.0	30000.0
11	ТЗА-ны талбайн орлого /дай/үйлч/	152471.0	200000.0	198553.8	190000.0	190000.0
12	Зам талбай ашиглалтын орлого	149580.9	100000.0	136916.0	115000.0	115000.0
13	Краны үйлчилгээний орлого	8701.6	20000.0	236.4		
14	Бункер ашиглалтын орлого	18400.0	50000.0			
15	Машин пүүлэлтийн орлого					
16	Авто тээврийн үйлчилгээний орлого					
17	Дулаан гражийн орлого	5445.5		1768.2		
18	Үйлчилгээний орлого	333.6				
19	Бараа хадгалалтын орлого	7626.2	5000.0		5000.0	5000.0
20	Үйлдвэрлэлийн орлого				255000.0	255000.0
21	Хөдлөх хөрөнгө борлуулсан орлого		5000.0	14909.1		
22	Үйл ажиллагааны бус бусад орлого	8008.4		9155.7		
23	Нийт орлого	7236313.2	1438000.0	7309857.5	7420138.5	7420138.5
24	Компанийн нийт зардлын дүн	7313981.2	1309673.5	7160794.2	7297901.5	7297901.5
25	Компанийн нийт ашгийн дүн	-77668.0	128326.5	149063.3	122237.0	122237.0
26	Улсын орлогын албан татвар		12832.7	7076.8	12223.7	12223.7
27	Компанийн нийт цэвэр ашиг	-77668.0	115493.9	141986.5	110013.3	110013.3
28	Нийт ажиллагсадын тоо	63	55	55	55	55
29	Ажиллагсадын цалингийн сан	181988.9	180000.0	138662.1	202800.0	202800.0
30	Нэг хүний дундаж цалин	240.7	272.7	210.1	307.3	307.3
31	Хөдөлмөрийн бүтээмж	9571.8	2178.8	11075.5	11242.6	11242.6
32	Орлогын нэг төгрөгт ноогдох зардал	1.01	0.91	0.98	0.98	0.98
33	Ашигт ажиллагааны түвшин	-0.01	0.09	0.02	0.02	0.02

ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛЖ  
НЭГТГЭСЭН: ЕРӨНХИЙ НЯ-БО

Д.ОЮУН

Хувь нийлүүлэгчдийн 2010 оны 04-р сарын 05-ны өдрийн хурлаар батлав.

МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2009 ОНЫ НИЙТ ЗАРДЛЫН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 2010 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

/мян.төг/

дд	Үзүүлэлтүүд	2008 оны гүйцэтгэл	2009 оны		2010 оны төлөвлөгөө	
			төлөвлөгөө	Гүйцэтгэл	Санал	баталсан
1	Цалингийн зардал	181988.9	156000.0	138662.1	202800.0	202800.0
2	Нийгмийн даатгал	20111.3	15600.0	16536.3	22308.0	22308.0
3	Сэлбэгийн зардал	4963.1	10000.0	4191.5	15000.0	15000.0
4	Шатахуун тээврийн зардал	19113.4	15000.0	10688.8	15000.0	15000.0
5	Цахилгаан эрчим хүч	36445.5	50000.0	24150.5	50000.0	50000.0
6	Халаалт халуун ус	7958.8	20000.0	10289.7	25000.0	25000.0
7	Усны зардал	844.5	2000.0	3394.6	5000.0	5000.0
8	Шуудан холбоо, интернет	12459.5	8000.0	9299.8	10000.0	10000.0
9	Томилолтын зардал	7105.5	3000.0	5911.5	8000.0	8000.0
10	Үндсэн хөрөнгийн элэгдэл	56766.8	50000.0	89414.1	90000.0	90000.0
11	Хангамжийн материал	2714.2	2000.0	1830.0	3500.0	3500.0
12	Газрын төлбөр	75293.5	75293.5	75293.5	75293.5	75293.5
13	Зээлийн хүү	107107.3	50000.0	37198.4		
14	Ариутгал цэвэрлэгээний зардал	3819.2	2000.0	496.4	2000.0	2000.0
15	Сурталчилгааны зардал	15.0	500.0	493.3	1000.0	1000.0
16	Засварын зардал	1711.8	5000.0	2000.9	5000.0	5000.0
17	Хөдөлмөр хамгаалалтын зардал +хөн	2951.0	3000.0	2274.9	5000.0	5000.0
18	Гаалийн эрсдлийн санд			50000.0		
19	Төмөр зам арчлалтын зардал	11623.9	12000.0	12158.1	12500.0	12500.0
20	Аудит программын зардал	4005.2	3000.0	3069.9	4000.0	4000.0
21	Банкны үйлчилгээний зардал	6766.7	1000.0	3096.2	3000.0	3000.0
22	Бичиг хэргийн зардал	9778.9	1000.0	4479.7	3000.0	3000.0
23	Гадаад тээврийн зардал	372437.7	500000.0	554112.5	1050000.0	1050000.0
24	ЗҮ- Вагон ашиглалт, ачаа хадгалалт	203948.8	10000.0	12983.4		
25	Ачаа хүргэлтийн зардал		5000.0		5000.0	5000.0
26	Үндсэн болон үйлдвэрлэлийн өртөг	5747506.8	269230.0	5956555.2	5660000.0	5660000.0
27	Үндсэн хөрөнгө акталсан зардал			4297.5		
28	Замын -Үүдийн рентген зардал	6134.0	6000.0	198.0		
29	ЗҮ - краны болон түрээсийн зардал	13338.6	20000.0			
30	Үл хөдлөх хөрөнгийн татвар 0.6%	5829.3	5500.0	6419.0	6500.0	6500.0
31	Түрээсийн зардал			771.8	1000.0	1000.0
32	ХАҮ танхим, Хөрөнгийн бирж	1300.0	1000.0	1512.5	2200.0	2200.0
33	Ажлын хөлс, ачилт буулгалтын хөлс	974.0	3000.0			
34	Хүлээн авалт, баяр ёслолын з.	7693.6	2000.0	4321.0	3000.0	3000.0
35	Шагнал урамшил	1882.4		291.5	5000.0	5000.0
36	Тээврийн хэрэгсэл, бууны татвар	653.5	500.0	703.0	700.0	700.0
37	Үндсэн хөрөнгө худалдсан алдагдал	2837.4		7131.5		
38	Хандив тусламж	4177.0	1000.0	1213.0	3000.0	3000.0
39	Сахарын акт ба ханшийн зөрүү	283.1	1000.0			
40	Хэвлэл захиалгын зардал	40.2	50.0	101.4	100.0	100.0
41	Татварын акт/ 2003 он+ НӨТ/	32501.8				
42	ЗҮ-дийн бусад зардал			1076.4		
43	Урд оны зардлын залруулга	25222.0		76960.7		
44	Даатгалын зардал			889.7	1000.0	1000.0
45	Бусад зардлууд /Зардлын залруулга/	313677.0	1000.0	26325.9	3000.0	3000.0
46	Компанийн нийт зардлын дүн	7313981.2	1309673.5	7160794.2	7297901.5	7297901.5